

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	8
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	11
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3. Менежментийн захидал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ТӨУҮГ	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 01/940
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Мөрөн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэхгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар данс бүртгэлд тусгахгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийг үндэслэлтэй бодитой тоо мэдээнд үндэслэн төлөвлөх, байгууллага, салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдсан, холбогдох, хууль, дүрэм, журам, тогтоолыг бүрэн тусгасан бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах, аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг хэрэгжүүлж ажиллах, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг ирүүлэх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 5-аас 2020 оны 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор И.Эрдэнэцэцэг хариуцан гүйцэтгэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 01/443 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго:

Байгууллагын эрхэм зорилгоо “Хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулахад оршино.” гэж тодорхойлсон.

Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

- Байгууллагын үйлчилгээний танхим дахь үйлчлүүлэгчийн дугаар дуудагч төхөөрөмж зөвхөн монгол хэлний сонголттой байсныг хөгжүүлэн англи, орос, хятад хэлний сонголтыг нэмсэн;
- Гадаадын иргэдийн бүртгэлийн журамтай холбоотой санамж мэдээллээр 60 секундийн видео санамж, товч ярилцлага, зурагт хуудсыг англи, монгол хэлээр бэлтгэн олон нийтэд хүргэсэн;
- Мэдээллийн дэлгэц /kiosk/-ийг үйлчилгээний танхимд байршуулан монгол, англи, солонгос, хятад хэл дээр долоон хэсэг мэдээллийг дөрвөн төрөлд хуваан үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн;
- Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын үйлчилгээг үзүүлж эхэлсэн;
- Хилийн боомтод виз, визийн зөвшөөрөл олгох үйлчилгээг цахимаар олгож эхэлсэн нь иргэд, үйлчлүүлэгчдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлэх, виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх зэрэг таатай нөхцлийг бүрдүүлж өгсөн;
- Иргэд, үйлчлүүлэгчдэд гадаадын иргэдийн бүртгэлийн талаарх мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор лавлагаа, мэдээллийн 1800-1882 дугаар утсан дээр автомат хариулагчийн системийг шинээр хийсэн;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2002 оны 213 дугаар тушаалаар “Визийн хуудас”-ны төлбөр 3 ам.доллар түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тэмдэгтийг улсын тэмдэгтийн хураамж дээр нэмж авдаг байсан нь хууль тогтоомжид нийцэхгүй тул энэ оны 06 дугаар сараас эхлэн зогсоосон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу

шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод аудитын хэлтэс 2019 онд харьяа орон нутаг дахь 3 газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 27 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж арга хэмжээ авч ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гадаадын иргэн, харьяатын газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 11,232.7 сая төгрөгийн 2 хувь буюу 224.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,155.6 сая төгрөгийн 2 хувь буюу 243.1 сая төгрөгөөр тогтоосон болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэн байна. Үүнээс 1 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлж, 6 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт өгсөн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5, ГИХГ-ын Баруун бүс дэх газарт “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 476.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 369.8 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 38.0 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгах 4 албан

шаардлага хүргүүлж, 68.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны бусад зардалд 221.3 сая төгрөгийн харьяа байгууллагуудын үндсэн үйл ажиллагаандаа зарцуулсан бараа материалын зардлыг тайлагнасан;

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

- ГИХГ-ын төв аппаратын 2019 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлийн дүн балансын үндсэн хөрөнгийн тодруулгын дүнгээс 113.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Харьяа байгууллагуудын удирдлагад хүргүүлсэн акт, албан шаардлага

1. ГИХГ-ын төв аппарат албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан албан тушаалын автомашин хэрэглэснээс 2.8 сая төгрөг, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтан автомашин хэрэглэснээс 3.4 сая төгрөг нийт 6.2 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2., Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “*Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай*” 184 дүгээр тогтоолын 2, 8 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “*Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай*” 4 дүгээр тогтоолын 6.6. заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. ГИХГ-ын Зүүн бүс дэх газар нь тайлант хугацааны худалдан авалтын и-баримтыг бүрэн хавсаргаагүй цахим ebarimt.mn сайтад бүртгэлгүй худалдан авалт хийсэн 29.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 "*анхан шатны баримт гэж ..., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*", 13 дугаар зүйлийн 13.4 "*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*"-ын 6.5, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "*татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага*"-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь урсгал засвараас цэвэр бохир усанд, дотоод албан томилолтоос автомашины дугуй худалдан авсан зэрэг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөл аваагүй, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй 0.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6. "... дээд шатны төсвийн захирагчийн

зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтуудтай нийцээгүй ба "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. ГИХГ-ын Баруун бүс дэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн.

Тус газар нь арилжааны банканд данс нээж дуудлага худалдаа, дэнчингийн орлогыг байршуулсан, нягтлан бодогч нь өөрийн хэрэгцээнд авсан цалингийн урьдчилгааг ажилчдаас суутган авсан, ажилчдын нормын хувцсыг тушаал шийдвэргүй бүртгэлээс хассан, өмнөх оны томилолтын мөнгийг өглөгөөр тусгаагүй олгосон зэрэг зөрчлүүд нь "үнэн зөв байдал", тохиолдсон байх", оршин байх", толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

5. ГИХГ-ын Зүүн бүс дэх газар тайлант оны эцэст 1.9 сая төгрөгийн шатахуун нөөцөлж он дамжуулан зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5. "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Төвлөрүүлэн захирагчийн 54.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 27.7 сая төгрөг байсан нь эцсийн үлдэгдэл 49.0 сая төгрөг болж, 21.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	27.7	49.0	21.3
Дүн	27.7	49.0	21.3

Эх сурвалж: ГИХГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 0.6 сая төгрөг арилжааны банкны дансанд, 2.3 сая төгрөг барьцаа дансанд, 46.0 сая төгрөг ахмадын сангийн дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлант хугацааны худалдан авалтын и-баримтыг бүрэн хавсаргаагүй цахим ebarimt.mn сайтад бүртгэлгүй 29,642.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. / ГИХГ-ын Зүүн бүс дэх газар 26.9 сая/
- Оны эцэст ахмадын санд цалингийн зардлаас 46.0 сая төгрөг шилжүүлсэн./ГИХГ-ын төв аппарат 46.0 сая/
- Ажил үйлчилгээг гэрээнд заасан нөхцөл шаардлагын дагуу хүлээж авсан эсэх нь тодорхойгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, хүлээж авсан акт байхгүй. /ГИХГ-ын Дорноговь дахь газар 1.5 сая/
- Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримттай тулган үзэхэд дуудлагын автомашиныг албан ажлаар бус хот дотор унаж шатахуун зарцуулсан, илүү нөөцөлсөн./ ГИХГ-ын Зүүн бүс дэх газар 13.7 сая/

- Монгол улсын засгийн газрын 2015 оны 184 тоот тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс шатахууныг илүү зарцуулсан./ГИХГ-ын төв аппарат 2.8 сая/
- Монгол улсын засгийн газрын 2016 оны 4 тоот тогтоолын 6.6. дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс албан ажлын автомашин унах эрхгүй албан тушаалтан албаны унаа унаж шатахууны зардал гаргасан./ГИХГ-ын 3.4 сая/
- Тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгосон./ГИХГ-ын төв аппарат 8.4 сая/

2.9.2 Урьдчилгаа

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	248.5	0	-248.5
Дүн	248.5	0	-248.5

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд худалдаж авсан үндсэн хөрөнгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэснийг энэ онд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

2.9.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 979.8 сая, эцсийн үлдэгдэл 1,157.9 сая төгрөг болж, 178.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалт			
Эм боох материал	0	2.8	2.8
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бичиг хэргийн материал	33.0	34.3	1.3
Аж ахуйн материал	200.8	188.2	-12.6
Сэлбэг хэрэгсэл	6.6	8.5	1.9
Түлш, шатах тос	40.4	44.5	4.1
Засварын материал	4.5	1.9	-2.6
Бусад хангамжийн материал	694.5	877.7	183.2
Дүн	979.8	1,157.9	178.1

Эх сурвалж: ШШҮХ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал өмнөх оноос өссөн шалтгаан нь нормын хувцас 247.4 сая төгрөгөөр худалдаж авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ГИХГ-ын төв аппарат нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/223 дугаар тушаалаар Цагаан шонхор ТӨУҮГ-аас 102.5 сая төгрөгийн нормын хувцас нийлүүлэх шууд гэрээ байгуулсан нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.,8.2.,8.4.,8.5. заалтуудыг зөрчсөн. Үүнд завсрын аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

2.9.4 Үндсэн хөрөнгө

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,651.2	8,198.4	547.2
Биет бус хөрөнгө	564.5	619.6	55.1

Дүн	8,215.7	8,818.0	602.3
------------	----------------	----------------	--------------

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант 2019 онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 176.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 1,601.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 149.9 сая, акталсан 57.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь бараа материалын дансанд 1.3 сая төгрөгийн компьютер, 0.4 сая төгрөгийн архивын шкаф, 0.6 сая төгрөгийн 3 үйлдэлт принтер, нийт 2.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн нь нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 13 (б)-д "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэж тодорхойлсон заалттай нийцээгүй бөгөөд "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.9.5 Урьдчилж орсон орлого

Хүснэгт №5 Урьдчилж орсон орлогын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Барьцаа	2.3	2.3	0
НИЙТ ДҮН	2.3	2.3	0

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үүнээс барьцаа дансны өглөг 2.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.9.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 9,469.5 сая, эцсийн үлдэгдэл 10,022.6 сая төгрөг болж, 553.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал			
/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,421.3	1,421.3	0
Өмч/ төрийн/	12.0	12.0	0
Хуримтлагдсан үр дүн	5,697.3	6,250.4	553.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,338.9	2,338.9	0
Дүн	9,469.5	10,022.6	553.1

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан урсгал зардалд 6,085.7 сая төгрөг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 6,085.7 сая төгрөгийн санхүүжилт авчээ.

Нийт зардлын 6,075.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 10.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс 6,075.7 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 11.5 сая төгрөг нийт 6,087.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж гүйцэтгэлээр, 5,997.1 сая төгрөгийг зарцуулж 90.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 3,578.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 3,531.1 сая төгрөгийг зарцуулж 46.9 сая төгрөгийг хэмнэсэн. Жирэмсэн, амаржсаны чөлөөтэй албан хаагчийн оронд түр орлон гүйцэтгэсэн албан хаагч томилогдсон, орон тоо дутуу ажилласан. Хэмнэлтээс ахмадын санд 46.0 сая төгрөг татсан.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12.9 сая, хангамж бараа материалын зардлыг 4.2 сая, норматив зардлыг 0.2 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.2 сая, томилолт зочны зардлыг 3.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 4.6 сая, бараа, үйлчилгээний бусад зардлыг 4.3 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 1.2 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 0.1 сая, нийт 30.8 сая төгрөгийн зардлыг хэмнэжээ.

Нэмэлт төсөв:

Нэмэлт санхүүжилтийн дансаар Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 20.0 сая, орон нутгийн төсвөөс үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 12.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон давсан орлого 62.9 сая төгрөг нийт 94.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 94.7 сая төгрөгийн үйл ажиллагаандаа зарцуулж, 0.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Гадаадын иргэн, харьяатын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 1043 мэдээллийг хугацаанд нь, 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гадаадын иргэн, харьяатын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга" гэж заасантай болон Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн тэмдэглэлийг бэлтгэх үлгэрчилсэн заавар"-тай нийцээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд хүрэх мэдээлэл тодорхой бус байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн үйл ажиллагаа болон нягтлан бодох бүртгэлийн онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн тэмдэглэлийг бэлтгэх үлгэрчилсэн заавар"-тай нийцүүлэн иж бүрэн бэлтгэж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэлд 8.4 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албан хаагч давхар цалин авах нь төрийн албаны зарчимд нийцэж буй эсэх нь тодорхойгүй байна.

3.2.2 Эрсдэл:

- Холбогдох хууль, журам заавар хэрэгжүүлээгүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны зөвлөл болон дээд шатны удирдлагад хандаж асуудлыг шийдвэрлэх, Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг дагуу холбогдох байгууллагад хандаж асуудлыг шийдвэрлэж ажиллана.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Оны эцэст ахмадын сан байгуулж цалингийн зардлын хэмнэлтээс 46.0 сая төгрөгийг тухай жилийн төсөвт суулгалгүй шилжүүлсэн нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" 197 тоот тогтоолын 1.3."Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана." Заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

- Төсөвт батлагдаагүй зардал гаргасан байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сангийн хөрөнгийг тухай жилийн төсөвт суулган батлуулж, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 197 тоот тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Дотоод хяналттай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн, тооллогын бүртгэлд тооцоо бодоогүй, анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, төсвийг үрэлгэн зарцуулсан, худалдан авалтыг холбогдох хууль, заавар журмын дагуу хийгээгүй, шатахуун илүү зарцуулсан цалингийн санг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх

талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

- Дотоод хяналтыг үр нөлөөгүй хэрэгжүүлснээс санхүүгийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал гарах;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.5.2 заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,181.8	1,206,867.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,656.0	48,957.4
АВЛАГА	168.8	0.0
УРЬДЧИЛГАА	248,520.8	0.0
БАРАА МАТЕРИАЛ	979,836.3	1,157,909.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,215,700.2	8,818,041.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,215,700.2	8,818,041.8
Биет хөрөнгө	7,651,193.8	8,198,435.3
Биет бус хөрөнгө	564,506.5	619,606.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,471,882.1	10,024,908.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,385.7	2,349.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,385.7	2,349.0
Өглөг	36.7	0.0
Урьдчилж орсон орлого	2,349.0	2,349.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,469,496.4	10,022,559.7
Засгийн газрын хувь оролцоо	9,469,496.4	10,022,559.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,421,292.5	1,433,292.5
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	12,000.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	5,697,351.7	6,250,415.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,338,852.2	2,338,852.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,471,882.1	10,024,908.7

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,824,196.2	11,579,019.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,254,720.4	5,446,349.5
120	Нийтлэг татварын бус орлого	5,227,046.6	5,446,349.5
122	Тусламжийн орлого	27,673.8	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,569,475.8	6,132,670.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,234,732.8	11,022,734.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,234,732.8	11,022,734.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,938,139.2	6,590,494.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,347,019.6	3,531,097.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	413,716.5	447,338.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,643.5	245,526.7
2104	Хангамж, бараа материалын зардал	519,084.2	409,201.6
2105	Нормативт зардал	26,152.0	7,033.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,399.9	195,935.0
2107	Томилолт, зочны зардал	64,357.7	83,470.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	247,303.7	464,753.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	929,462.1	1,206,137.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,296,593.6	4,432,240.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	589,463.4	556,284.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	532,989.9	3,221.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	56,473.4	553,063.3

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,244,327.5	10,208,150.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,640,862.3	4,037,547.2
120	Нийтлэг татварын бус орлого	4,640,862.3	4,037,547.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,603,465.2	6,170,603.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,761,162.9	10,009,898.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,761,162.9	10,009,898.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,527,254.7	5,535,588.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,346,982.9	3,531,133.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	413,716.5	447,170.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,823.5	247,246.4
2104	Хангамж, бараа материалын зардал	397,169.5	377,236.0
2105	Нормативт зардал	250,684.7	251,338.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	172,873.3	201,838.2
2107	Томилолт, зочны зардал	66,426.0	85,173.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,389.4	249,481.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	384,188.8	144,970.5
212	ТАТААС	10,196.8	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,223,711.4	4,474,310.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	483,164.6	198,251.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	479,914.5	176,950.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	479,914.5	176,950.5
2200	Дотоод эх үүсвэрээр	479,914.5	176,950.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-479,914.5	-176,950.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,250.1	21,301.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,405.9	27,656.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,656.0	48,957.4

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,357,377.4	0.0	6,357,377.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	771,288.2	0.0	771,288.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,128,665.6	0.0	7,128,665.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,284,357.4	0.0	2,284,357.4
Тайлант үеийн үр дүн	56,473.4	0.0	56,473.4
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,469,496.4	0.0	9,469,496.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,469,496.4	0.0	9,469,496.4
Тайлант үеийн үр дүн	553,063.3	0.0	553,063.3
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,022,559.7	0.0	10,022,559.7

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,085,660.1	5,997,088.1	88,572.0	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,085,660.1	5,997,088.1	88,572.0	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,758,312.7	5,670,938.8	87,373.9	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,578,021.9	3,531,133.8	46,888.1	98.7
210101	Үндсэн цалин	2,201,892.6	2,197,711.1	4,181.5	99.8
210102	Нэмэгдэл	991,252.8	961,226.4	30,026.4	97.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	384,876.5	372,196.3	12,680.2	96.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	458,091.6	447,170.0	10,921.6	97.6
210201	Тэтгэврийн даатгал	320,514.1	315,184.5	5,329.6	98.3
210202	Тэтгэмжийн даатгал	33,728.7	30,119.5	3,609.2	89.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,354.5	27,358.5	-4.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	7,163.2	5,996.4	1,166.8	83.7
210205	Эрүүл мэндийн даатгал	69,331.1	68,511.1	820.0	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	260,198.2	247,246.4	12,951.8	95.0
210301	Гэрэл, цахилгаан	75,449.5	72,256.1	3,193.4	95.8
210302	Түлш, халаалт	66,022.2	64,372.9	1,649.3	97.5
210303	Цэвэр, бохир ус	22,018.0	16,191.2	5,826.8	73.5
210304	Байрны түрээс	96,708.5	94,426.2	2,282.3	97.6
2104	Хангамж, бараа материалын зардал	376,775.2	372,636.0	4,139.2	98.9
210401	Бичиг хэрэг	50,550.5	50,381.5	169.0	99.7
210402	Тээвэр, шатахуун	192,807.0	192,747.0	60.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,135.7	48,830.5	1,305.2	97.4
210404	Ном, хэвлэл	12,050.0	11,701.4	348.7	97.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,232.0	68,975.7	2,256.3	96.8
2105	Нормативт зардал	251,517.5	251,338.1	179.4	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,000.0	3,911.1	88.9	97.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	247,517.5	247,427.0	90.5	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	370,992.3	370,788.7	203.6	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	177,042.4	176,950.5	91.9	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,300.0	2,300.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	191,649.9	191,538.2	111.7	99.9
2107	Томилолт, зочны зардал	88,252.7	85,173.4	3,079.3	96.5
210702	Дотоод албан томилолт	63,752.7	60,901.9	2,850.8	95.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	24,500.0	24,271.5	228.5	99.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	254,119.8	249,481.8	4,638.0	98.2

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,748.9	173,568.7	2,180.2	98.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,580.6	1,574.0	6.6	99.6
210803	Даатгалын үйлчилгээ	9,118.4	9,118.4	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,886.5	2,843.4	43.1	98.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	723.6	645.9	77.7	89.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,175.0	40,754.6	1,420.4	96.6
210807	Газрын төлбөр	1,350.8	974.1	376.7	72.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,536.0	20,002.8	533.2	97.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,343.5	115,970.5	4,373.0	96.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,540.5	70,672.2	-131.7	100.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,803.0	45,298.3	4,504.7	91.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,347.4	326,149.3	1,198.1	99.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	327,347.4	326,149.3	1,198.1	99.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,400.0	15,210.0	1,190.0	92.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	301,795.4	301,795.3	0.1	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,152.0	9,143.9	8.1	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,085,660.1	5,997,088.1	88,572.0	98.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,075,660.1	5,985,596.2	90,063.9	98.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	6,075,660.1	5,985,596.2	90,063.9	98.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000.0	11,491.9	-1,491.9	114.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000.0	11,491.9	-1,491.9	114.9
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	619.0	589.0	30	95.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.0	7.0	0	100.0
610001	Төсвийн байгууллага	7.0	7.0	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	306.0	291.0	15	95.1
620001	Удирдах ажилтан	2.0	2.0	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	222.0	203.0	19	91.4
620003	Үйлчлэх ажилтан	82.0	86.0	-4	104.9

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		94,943.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		94,943.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		41,600.0
2104	Хангамж, бараа материалын зардал		4,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,000.0
210604	Урсгал засвар		8,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		29,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		27,000.0
212	ТАТААС		11,380.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		11,380.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		11,380.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		41,963.1
2132	Бусад урсгал шилжүүлэг		15,243.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		15,243.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		26,719.2
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		166.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		26,553.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		94,943.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		94,943.1
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		62,943.1

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:		Аудитын нэр:	Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:	
2020.03.25				САГ-2020/12/СТА-ТТЗ	
Шалгагдсан байгууллагын нэр:		Гадаадын иргэн, харьяатын газар		Сая төгрөгөөр	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Оны эцэст ахмадын санд цалингийн зардлаас 46.0 сая төгрөг шилжүүлсэн.	46.0	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Д.Мөрөн Б.Даваажав
2	Монгол улсын засгийн газрын 2015 оны 184 тоот тогтоолын 2. заалтыг хэрэгжүүлээгүйгээс шатахуун илүү зарцуулсан.	2.8	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	
3	Тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгосон.	8.4	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	
4	Монгол улсын засгийн газрын 2016 оны 4 тоот тогтоолын 6.6. заалтыг хэрэгжүүлээгүйгээс албан ажлын автомашин унах эрхгүй албан тушаалтан албаны унаа унаж шатахууны зардал гаргасан.	3.4	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	
5	Ажил үйлчилгээг гэрээнд заасан нөхцөл шаардлагын дагуу хүлээж авсан эсэх нь тодорхойгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, хүлээж авсан акт байхгүй.	1.5	Зөвлөмж	ГИХГ-ын Дорноговь дахь газар	
6	Арилжааны банканд данс нээлгэж акталсан автомашины дуудлага худалдааны дэнчингийн орлого, дуудлага худалдааны төлбөрийн 8,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн 100900000721 тоот дансанд төвлөрүүлсэн.	8.0	Зөвлөмж	ГИХГ-ын Баруун бүс дэх газар	

7	Иргэн Г.Батбаяртай байгуулсан түрээсийн гэрээнд гэрээний дагуу төлбөрийг бүрэн барагдуулсан тохиолдолд түрээслүүлж буй гараашийн эзэмших эрхийг түрээслэгчид шилжүүлэхээр харилцан тохиролцон, түрээсийн төлбөрийг бүрэн барагдуулсан боловч тухайн хөрөнгийн эзэмших эрхийг байгууллагын нэр дээр шилжүүлэн аваагүй байна.		Зөвлөмж	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	Д.Мөрөн Б.Даваажав
8	Бараа материалын дансанд 1261.0 мянган төгрөгийн компьютер, 593.0 мянган төгрөгийн архивын шкаф, 579.0 мянган төгрөгийн 3 үйлдэлт принтер, нийт 2433.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн.	2.4	Зөвлөмж	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	
9	Тушаалын шийдвэрийн хэрэгжилт: Газрын даргын тушаалаар албан тушаалын сарын цалинг тодорхой хэмжээгээр бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулахдаа үндсэн цалинг тогтоосон хувиар бууруулах бус нийт бодогдсон цалинг холбогдох хувиар бууруулан суутгасан.		Зөвлөмж	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	
10	ГИХГ-ын Хойд бүс дэх газар нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй		Зөвлөмж	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	
11	Урсгал засвараас 26.7 мянган төгрөгийг цэвэр бохир усанд, дотоод албан томилолтоос 291.7 мянган төгрөгийг автомашины дугуй худалдан авахад зэрэг нийт 318.4 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөл аваагүй, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.	0.3	Албан шаардлага	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	
12	Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримттай тулган үзэхэд дуудлагын автомашиныг албан ажлаар бус хот дотор 1827.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1.8	Зөвлөмж	ГИХГ-ын Зүүн бүс дэх газар	
13	1. Тайлант оны эцэст 1,879.2 мянган төгрөгийн шатахуун нөөцөлж он дамжуулсан байна.	1.9	Албан шаардлага	ГИХГ-ын Зүүн бүс дэх газар	
14	Тайлант хугацааны худалдан авалтын и-баримтыг бүрэн хавсаргаагүй цахим ebarimt.mn сайтад бүртгэлгүй 29,642.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрлээ.	29.6	Албан шаардлага	ГИХГ-ын Зүүн бүс дэх газар	
	Дүн	106.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25 № 01/168
С.А.Г. 2020/12/СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан албан тушаалын автомашин хэрэглэснээс шатахуун илүү зарцуулсан 2,863,810.00 /хоёр сая найман зуун жаран гурван мянга найман зуун арав / төгрөг, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтан автомашин хэрэглэснээс 3,391,000.00/ гурван сая гурван зуун ерэн нэгэн мянга/ төгрөг нийт 6,254,810.00/ зургаан сая хоёр зуун тавин дөрвөн мянга найман зуу/ төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 184 дүгээр тогтоолын 2-т "албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км..... хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай.", 8."Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай." Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоолын 6.6. "Засгийн газрын агентлагийн дарга нь төсөвт зардлыг хэмнэх шаардлагыг харгалзан зөвлөхгүй байх, албан ажилдаа жижиг оврын автомашин хэрэглэх, "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолд заагаагүй албан тушаалтан албан ажлын автомашин хэрэглэхгүй байх." зэрэг заалтуудыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richip_Kheree\Alban Shaardлага\2020\0325SAG4.Docx

001080563

1. Шатахуун илүү зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах;
2. Монгол улсын Засгийн газрын тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллах;
3. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, ахлах нягтлан бодогч Б.Даваажав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
 И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА
 Д.МӨРӨН
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
 Б.ДАВААЖАВ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэнэ.

